



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДОА-2020/70/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Чойбалсан хот 2020 он</p>	<p>Дорнод аймаг дахь Төрийн аудит газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор: Б.Болортуул Утас: 70584203 Цахим хаяг: Bolortuulb@audit.gov.mn Аудитын менежер: В.Цэнгэлмаа Утас: 70584204 Цахим хаяг: Tsengelmaav@audit.gov.mn Ахлах аудитор: Б.Батжаргал Утас: 70584207 Цахим хаяг: Batjargalb@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ДОА	Аудитын Олон Улсын Стандарт
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
НББ	Нягтлан бодох бүртэл



Агуулга

<b>Аудитын гэрчилгээ</b> .....	3
Аудитын тайлан .....	4
2.1. Оршил.....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	6
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	6
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	8
2.13. Шилэн дансны мэдээлэл.....	8
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт .....	8
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл .....	8
Менежментийн захидал .....	9
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан .....	10
1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан .....	10
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	10
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	12
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	14
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	14





## 2.1. Оршил

Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг дарга М.Алтаннавч танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

## 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 25-аас 2020 оны 02 дугаар сарын 06-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 07-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, ахлах аудитор Б.Батжаргал хариуцаж хэрэгжүүлэв.

Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 15 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

## 2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Төрийн аудитын байгууллагаас



санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

#### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн эрхэм зорилго нь “Ус, цаг уурын хяналт шинжилгээг хийж, үнэн зөв мэдээллээр хэрэглэгчдийг хангах”-д оршино.

Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Ус цаг уур, уур амьсгал, байгаль орчны бодит болон ирээдүйн төлөв байдлын тухай мэдээллээр төр засаг, нийгэм эдийн засаг, хүн амын эрэлт хэрэгцээг хангах,
- Ус цаг уур, уур амьсгал, байгаль орчин, тандан судалгаа хийх, мэргэжлийн дүгнэлт, зөвлөмж, үнэлгээ гаргах,

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт гараагүй байна.

#### **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Ус, цаг уур, орчны шинжилгээний төв нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Acoluos программ хангамж ашигладаг байна.

Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

#### **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитаар Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 17 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.



## 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 799,789.9 мянган төгрөгөөс тооцон 15,995.8 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 19,538.9 мянган төгрөгөөр тооцсон нь 2019 онд зардлын гүйцэтгэл өссөнтэй холбоотой байна.

## 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 67.8 сая төгрөгөөр буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан данс байхгүй байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Авлага	0	0	0
Урьдчилгаа	0	0	0
Бараа материал	94,839.9	93,347.4	-1,492.4
Үндсэн хөрөнгө	797,245.6	730,966.0	-66,279.5
<b>Нийт хөрөнгө</b>	<b>892,085.5</b>	<b>824,313.5</b>	<b>-67,771.9</b>
Өр төлбөр	0	0	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	892,085.5	824,313.5	-67,771.9
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>892,085.5</b>	<b>824,313.5</b>	<b>- 67,771.9</b>

Бараа материалын дансны үлдэгдэл буурсан нь 1,492.4 мянган төгрөгийн материалыг эхний үлдэгдлээс зарцуулсантай холбоотой байна

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 824,313.5 мянган төгрөг бол 67,771.9 мянган төгрөгөөр буурсан нь элэгдлийн зардлын хэмжээгээр үр дүн буурснаас шалтгаалсан байна.

## 2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Үндсэн үйл ажиллагааны орлого 130.0 мянган төгрөг төлөвлөснөөс 242.0 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг 112.0 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.



Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан 824,042.3 мянган төгрөг урсгалд зардалд зарцуулагдахаар батлагджээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

**Нэмэлт төсөв:** Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах хөрөнгөнөөс 23,000.0 мянган төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос 5,259.9 мянган төгрөг, нийт 28,259.9 мянган төгрөгийн нэмэлт төсвийг бүрдүүлжээ.

Үүнээс тээвэр шатахууны зардалд 4,706.6 мянган төгрөг, шуудан холбооны зардалд 2,227.4 мянган төгрөг, эд хогшил худалдан авах зардалд 7,000.0 мянган төгрөг, бараа, үйлчилгээний бусад зардалд 14,325.9 мянган төгрөг, нийт 28,259.9 мянган төгрөгийг зарцуулсан байна.

## 2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 17 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 17 эрсдэл тодорхойлж нийт 17 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 60,570.8 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 15,059.7 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 868.2 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 44,642.9 мянган төгрөгийн алдаа, зөрчилд залруулга хийлгэлээ.

Аудитаар 15,927.9 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 15,059.7 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага, 868.2 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоосон. Үүнд:

1. Бараа материалын худалдан авалтын 57 хувь буюу 15,059.7 мянган төгрөгийн анхан шатны баримтад е-баримтыг хавсаргаагүй нь *Нягтлан бодох бүртгэлийн хуулийн 3.1.3 дахь заалтад “анхан шатны баримт гэж ....., төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог”, 13.4 дэх хэсэгт “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна.”*, 13.5 дахь хэсэгт “... цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна”, Төсвийн тухай хуулийн 41.2.3 дахь заалтад “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”, 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын 6.5 дахь Монгол Улсын стандарт MNS 6529:2015 “татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан тусгай нууцлалын QR кодоор баталгаажсан анхан шатны цаасан баримтуудыг бүрдүүлж ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч Е баримтыг хавсаргах” гэсэн заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн иж бүрэн, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

2. Цалинг шалгах явцад ажилтанд илүү цаг ажилласан бүртгэл баримтгүйгээр 228.8 мянган төгрөгийн илүү цагийн хөлс олгосон, ээлжийн амралтын олговор 639.4 мянган төгрөгийг цалинтай давхардуулан олгосон нь Хөдөлмөрийн хуулийн 79 дүгээр зүйл “79.1. Ажилтанд жил бүр



ээлжийн амралт олгож биеэр эдлүүлнэ...”, ЗГ-ын 2018 оны 382 дугаар тогтоол "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам"-ын 4 дэх заалт заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн тохиолдсон байх, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

#### **2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

#### **2.12. Шилэн дансны мэдээлэл**

**Ус, цаг уур, орчны шинжилгээний төв нь** Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

#### **2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн зөвлөмжийн хэрэгжүүлж 2019 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн 130 тоот албан бичгээр хариу ирүүлсэн байна.

#### **2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид **Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн** 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

**Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн** 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 дугаар зүйл, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.



Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. *МУЕА-аас өгсөн чиглэлийн дагуу биет бус хөрөнгийн элэгдлийн талаар*
  - 1.1. *Илрүүлэлт*: Биет бус хөрөнгө болох газарт 14,328.0 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэл тооцсон байна.
  - 1.2. *Эрсдэл*: Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх.
  - 1.3. *Өгсөн зөвлөмж*: Биет бус хөрөнгө болох газарт хуримтлагдсан элэгдэл тооцохгүй байх.
  - 1.4. *Байгууллагаас өгсөн хариу тайлбар*: Өгсөн зөвлөмжийг мөрдөж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

**1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан**

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>94,839,904.98</u></b>	<b><u>93,347,474.98</u></b>
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	94,839,904.98	93,347,474.98
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	62,863,794.58	62,863,794.58
35110	Тусгай зориулалттай материал	62,863,794.58	62,863,794.58
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	24,956,110.40	24,858,680.40
35420	Аж ахуйн материал	23,984,350.40	24,529,600.40
35440	Түлш, шатах тослох материал	971,760.00	329,080.00
35600	Мал амьтад	7,020,000.00	5,625,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>797,245,603.68</u></b>	<b><u>730,966,096.00</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	797,245,603.68	730,966,096.00
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	361,155,603.68	294,876,096.00
39201	Барилга, байгууламж, орон сууц	231,325,640.00	231,325,640.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-13,033,702.08
39203	Авто-тээврийн хэрэгсэл	33,612,667.00	33,612,667.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-33,612,667.00	-33,612,667.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	399,719,639.46	408,599,329.46
39206	Хуримтлагдсан элэгдэл	-275,619,859.37	-336,214,355.13
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	15,713,785.89	15,713,785.89
39208	Хуримтлагдсан элэгдэл	-10,008,602.30	-11,539,602.14
39217	Ном	25,000.00	25,000.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	436,090,000.00	436,090,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	436,090,000.00	436,090,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>892,085,508.66</u></b>	<b><u>824,313,570.98</u></b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>892,085,508.66</u></b>	<b><u>824,313,570.98</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	892,085,508.66	824,313,570.98
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	848,771,602.64	848,771,602.64
51101	Өмч: - төрийн	848,771,602.64	848,771,602.64
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	-281,219,354.40	-348,991,292.08
51210	Өмнөх үеийн үр дүн	-281,219,354.40	-281,219,354.40
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-67,771,937.68
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	324,533,260.42	324,533,260.42
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>892,085,508.66</u></b>	<b><u>824,313,570.98</u></b>

**4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/



Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>812,384,980.90</b>	<b>909,072,811.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>62,381,958.90</b>	<b>42,128,931.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	62,381,958.90	42,128,931.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	62,381,958.90	42,128,931.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	342,000.00	242,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	62,039,958.90	41,841,931.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>750,003,022.00</b>	<b>866,943,880.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	727,106,400.00	824,042,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	727,106,400.00	824,042,300.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	14,333,360.00	28,109,900.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	23,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,533,360.00	5,109,900.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	8,563,262.00	14,791,680.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	8,563,262.00	14,791,680.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>799,789,970.78</b>	<b>976,844,748.68</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>799,789,970.78</b>	<b>976,844,748.68</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	779,426,118.78	956,834,906.68
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	604,320,615.00	690,354,100.00
210101	Үндсэн цалин	495,413,500.00	551,762,800.00
210102	Нэмэгдэл	82,623,600.00	112,292,000.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	26,283,515.00	26,299,300.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	72,325,667.00	86,294,200.00
210201	Тэтгэврийн даатгал	48,432,397.00	58,680,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	6,035,300.00	6,903,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,580,270.00	5,522,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,207,000.00	1,380,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	12,070,700.00	13,807,100.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	14,442,578.00	15,757,830.00
210301	Гэрэл, цахилгаан	3,018,957.00	3,821,601.00
210302	Түлш, халаалт	7,308,916.00	7,317,130.00
210303	Цэвэр, бохир ус	4,114,705.00	4,618,300.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	15,210,870.00	20,342,419.00
210401	Бичиг хэрэг	1,518,013.00	1,649,410.00
210402	Тээвэр, шатахуун	9,643,481.00	11,340,642.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,775,776.00	3,304,973.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	373,600.00	597,394.00
210408	Бараа материал акталсны зардал	900,000.00	3,450,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	420,500.00	406,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	420,500.00	406,500.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	2,312,060.00	34,377,842.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	360,000.00	29,269,242.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	60,150.00	284,300.00



210604	Урсгал засвар	1,891,910.00	4,824,300.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>7,020,220.00</b>	<b>5,493,500.00</b>
210702	Дотоод албан томилолт	7,020,220.00	5,493,500.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>8,834,180.00</b>	<b>8,299,120.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,006,138.00	6,351,800.00
210803	Даатгалын үйлчилгээ	123,020.00	582,620.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	125,200.00	128,900.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	29,700.00	35,700.00
210807	Газрын төлбөр	1,193,722.00	1,200,100.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>54,539,428.78</b>	<b>95,404,945.68</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	673,520.00	20,114,548.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	589,000.00	131,200.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	53,276,908.78	75,159,197.68
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>20,363,852.00</b>	<b>20,114,842.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>17,301,062.00</b>	<b>19,777,680.00</b>
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	8,563,262.00	14,791,680.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	8,737,800.00	4,986,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>3,062,790.00</b>	<b>337,162.00</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,062,790.00	337,162.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>12,595,010.12</u></b>	<b><u>-67,771,937.68</u></b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>12,595,010.12</u></b>	<b><u>-67,771,937.68</u></b>

#### 4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>750,153,022.00</u></b>	<b><u>867,185,880.00</u></b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>150,000.00</b>	<b>242,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	150,000.00	242,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	150000.00	242000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	150,000.00	242,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>750,003,022.00</b>	<b>866,943,880.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>727,106,400.00</b>	<b>824,042,300.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	727,106,400.00	824,042,300.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>14,333,360.00</b>	<b>28,109,900.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	23,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,533,360.00	5,109,900.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>8,563,262.00</b>	<b>14,791,680.00</b>
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	8,563,262.00	14,791,680.00



2	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>750,153,022.00</b>	<b>867,185,880.00</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>750,153,022.00</b>	<b>867,185,880.00</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>729,789,170.00</b>	<b>847,071,038.00</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	604,320,615.00	690,354,100.00
210101	Үндсэн цалин	495,413,500.00	551,762,800.00
210102	Нэмэгдэл	82,623,600.00	112,292,000.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	26,283,515.00	26,299,300.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	72,325,667.00	86,294,200.00
210201	Тэтгэврийн даатгал	48,432,397.00	58,680,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	6,035,300.00	6,903,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,580,270.00	5,522,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,207,000.00	1,380,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	12,070,700.00	13,807,100.00
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	16,524,382.00	15,909,830.00
210301	Гэрэл, цахилгаан	3,491,977.00	3,974,400.00
210302	Түлш, халаалт	8,917,700.00	7,317,130.00
210303	Цэвэр, бохир ус	4,114,705.00	4,618,300.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	16,322,240.00	14,532,700.00
210401	Бичиг хэрэг	1,081,500.00	694,500.00
210402	Тээвэр, шатахуун	11,198,341.00	10,446,937.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,398,799.00	3,300,363.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	643,600.00	90,900.00
2105	<b>Нормативт зардал</b>	443,500.00	443,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	443,500.00	443,500.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	3,796,116.00	12,317,300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	874,500.00	7,611,800.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	439,200.00	256,600.00
210604	Урсгал засвар	2,482,416.00	4,448,900.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	7,020,220.00	5,493,500.00
210702	Дотоод албан томилолт	7,020,220.00	5,493,500.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	8,181,210.00	8,262,120.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,353,168.00	5,958,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	356,400.00	356,400.00
210803	Даатгалын үйлчилгээ	123,020.00	552,620.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	125,200.00	158,900.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	29,700.00	35,700.00
210807	Газрын төлбөр	1,193,722.00	1,200,100.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	855,220.00	13,169,788.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	266,220.00	13,169,288.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	589,000.00	294,500.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>20,363,852.00</b>	<b>20,114,842.00</b>
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	17,301,062.00	19,777,680.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	8,563,262.00	14,791,680.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	8,737,800.00	4,986,000.00
2133	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	3,062,790.00	337,162.00



213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,062,790.00	337,162.00
--------	-----------------------	--------------	------------

#### 4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	00.00	00.00
C08	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	848,771,602.64	324,533,260.42	-281,219,354.40	892,085,508.66
D01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	848,771,602.64	324,533,260.42	-281,219,354.40	892,085,508.66
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	848,771,602.64	324,533,260.42	-281,219,354.40	892,085,508.66
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-67,771,937.68	-67,771,937.68
D09	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	848,771,602.64	324,533,260.42	-348,991,292.08	824,313,570.98

#### 4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	824,172,300.00	819,117,750.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	824,172,300.00	819,117,750.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	824,172,300.00	819,117,750.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	690,354,100.00	690,354,100.00



210101	Үндсэн цалин	551,762,800.00	551,762,800.00
210102	Нэмэгдэл	112,292,000.00	112,292,000.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	26,299,300.00	26,299,300.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>86,294,200.00</b>	<b>86,294,200.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	58,680,100.00	58,680,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	6,903,500.00	6,903,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,522,900.00	5,522,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,380,600.00	1,380,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	13,807,100.00	13,807,100.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>2,045,100.00</b>	<b>2,045,100.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	3,974,400.00	3,974,400.00
210302	Түлш, халаалт	7,317,300.00	7,317,130.00
210303	Цэвэр, бохир ус	4,618,300.00	4,618,300.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>1,200,900.00</b>	<b>1,200,900.00</b>
210401	Бичиг хэрэг	694,500.00	694,500.00
210402	Тээвэр, шатахуун	5,740,300.00	5,740,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,073,000.00	1,073,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	90,900.00	90,900.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>443,500.00</b>	<b>443,500.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	443,500.00	443,500.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>5,317,300.00</b>	<b>5,317,300.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	611,800.00	611,800.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	256,600.00	256,600.00
210604	Урсгал засвар	4,448,900.00	4,448,900.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>4,644,200.00</b>	<b>4,643,500.00</b>
210702	Дотоод албан томилолт	4,644,200.00	4,643,500.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>8,329,800.00</b>	<b>8,262,120.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,958,400.00	5,958,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	356,400.00	356,400.00
210803	Даатгалын үйлчилгээ	590,000.00	552,620.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	158,900.00	158,900.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66,000.00	35,700.00
210807	Газрын төлбөр	1,200,100.00	1,200,100.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>294,500.00</b>	<b>294,500.00</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	294,500.00	294,500.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>4,986,000.00</b>	<b>4,986,000.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>4,986,000.00</b>	<b>4,986,000.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	4,986,000.00	4,986,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>69,781,500.00</b>	<b>69,781,500.00</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>69,781,500.00</b>	<b>69,781,500.00</b>



Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

131001	Улсын төсвөөс санхүүжих	824,042,300.00	823,861,750.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	130,000.00	242,000.00